



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Цэвэгдоржийн ТУВААН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-25-19, Факс: 32-70-16
E-mail: tuvaants@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.01.17 № УИХ-03/461
танай _____-ны № _____-т


Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26-р зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5-р дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу **“Нас барсан өндөр насны тэтгэврийн зээл авагчийн тэтгэврийн зээл чөлөөлөх тухай”** хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их хурлын чуулган болон байнгын хороогоор хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ц.ТУВААН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Цэвэгдоржийн ТУВААН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-25-19, Факс: 32-70-16
E-mail: tuvaants@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.01.13 № УЦХ-03/331
танай _____-ны № _____-т

Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Нас барсан өндөр насны тэтгэврийн зээл авагчийн тэтгэврийн зээлийг чөлөөлөх тухай" хуулийн төслийг санаачлан боловсруулсныг хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх тов тогтоолгохоор хүргүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт 27... хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ц.ТУВААН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Цэвэгдоржийн ТУВААН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-25-19, Факс: 32-70-16
E-mail: tuvaants@parliament.mn
<http://www.parliament.mn>

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

2021.11.17 № УИХ-03/11183
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд **"Нас барсан өндөр насны тэтгэвэрийн зээл авагчийн тэтгэвэрийн зээл чөлөөлөх тухай"** хуулийн төслийг боловсрууллаа. Иймд уг хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу боловсруулсан хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгаа тооцооны хамт хүргүүлж байна. Та хуулийн төсөлд саналаа ирүүлнэ үү.

Хавсралт **26** хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ц.ТУВААН

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ТУВААН

**НАС БАРСАН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ АВАГЧИЙН
ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн шаардлага

Монгол Улсад үйлчилж байгаа нийгмийн хамгааллын бодлого шинэчлэн өөрчлөгдсөөр байгаа хэдий боловч зорилтод бүлгийн иргэдийн амьдралын наад захын хэрэгцээг хангахгүй, дутагдалтай байсаар байна. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн хэмжээ харилцан адилгүй, ялгаатай, Засгийн газраас амьжиргааны баталгаажих төвшинг тогтоосон мөнгөн дүнгээс дөнгөж дээгүүр байгаа байдал нь шударга, энэрэнгүй зарчимд суурилдаг манай улсын тэтгэврийн тогтолцоонд нийцэхгүй байгаагаас тэтгэвэр тогтоолгосон иргэдийн дийлэнх нь зээл авч, түүнийгээ төлж чадахгүй насан эцэслэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... иргэнийхээ өмнө Төр хариуцна.", Монгол Улсын төрөөс хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогыг тодорхойлж нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон улс орныхоо онцлогт нийцсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2015-2030 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.1.1-д "Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах", 3.2.1-д "тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх", Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.5-д "Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ" гэж тус тус заасан ч хэрэгжихгүй байгаа.

Хэрэв дээр дурдсан төрийн бодлого, шийдвэрүүд хэрэгжиж чадвал өндөр насны тэтгэвэр тогтоолгогч тэтгэврийн зээл авахгүй байх боломжтой.

1.2. Практик шаардлага

Сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ ханш эрс нэмэгдэж тэтгэвэр авагчдын худалдан авах чадварт, ялангуяа ахмад настануудын амьжиргаанд хүндээр байгаагаа ихэнх өндөр настангууд тэтгэврийн зээл авч амьжиргаагаа залгуулж байна.

2020 оны байдлаар Нийгмийн даатгалын сангаас нийт 441,201 мянган хүн өндөр насны тэтгэвэр авч байгаагаас 277,527 орчим нь 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөс доош тэтгэвэр авч байна. Үүнийг өрхийн дундаж зарлагын хэмжээтэй харьцуулан авч үзвэл нийт ахмадуудын 60 орчим хувь нь 500,000 /таван зуун мянга/ төгрөг хүрэхгүй тэтгэвэр авч, нэг өрхийн хоёр өндөр настан нийлээд дээр дурдсан өрхийн дундаж зарлагын 50 хувьд ч хүрэхээргүй хэмжээний тэтгэврийн орлогоор амьдарч байгаа бөгөөд энэ нь улс орон, үр хүүхэд, хойч ирээдүйнхээ төлөө насаараа зүтгэн хөдөлмөрлөсөн, тэтгэврээс өөр орлогогүй ахмадуудыг амьдралынхаа наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа тул тэтгэврийн зээл авч амьдарч байна.

Үндэсний статистикийн хорооноос Дэлхийн банктэй хамтран хоёр жил тутамд танилцуулдаг ядуурлын түвшингийн 2018 оны үзүүлэлтээр Монгол Улсын нийт хүн амын 28.4 хувь буюу 904,900 хүн ядуу амьдарч байгааг тогтоожээ.

Эдгээр ядуу иргэдийн тоонд өндөр насны тэтгэврээр амьдардаг ахмадуудын олонх нь хамаарах болсныг амьдралын бодит нөхцөл, авч буй тэтгэврийн хувь хэмжээ, тэдний авч буй тэтгэврийн зээлийн дүн нотлон харуулж байна.

Төрийн зүгээс нийгмийн даатгалын хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх, хүний амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн үүрэг юм. Тэтгэвэр авагч иргэн бол төрөөс зүгээр сууж байгаад халамж нэхэж, төсөвт хүндрэл учруулж байгаа иргэн биш, тэд ажиллаж хөдөлмөрлөж тодорхой хугацаанд ирээдүйд эдийн засгийн баталгаатай амьдрах үүднээс Нийгмийн даатгалын шимтгэлээ тухайн цаг үеийнхээ мөнгөний ханшаар төлсөн иргэн. Тэгэхээр өөрийн бий болгосон хуримтлалаа ирээдүйд авахдаа амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг нь хангаж чадахгүй, тэднийг ядууралд түлхэж тэтгэврийн зээл авахад хүргэж байна гэж дүгнэж байна.

Монгол Улсын иргэдийн дундаж наслалт эрэгтэй 66, эмэгтэй 75 байхад иргэдийн тэтгэврт гарах насыг нэмэгдүүлсэн нь олон жил хөдөлмөрлөж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэд тэтгэврийн насанд хүрээд тэтгэвэр авч чадахгүй эсхүл цөөхөн жил тэтгэвэр авахдаа зээлээс зээлийн хооронд амьдрасаар насан эцэслэж байгаа нь энэхүү хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлагатайг илэрхийлж байна.

Өндөр насны тэтгэврийн зээл аваад төлж чадаагүй нас барсан иргэд бол ажил хөдөлмөр эрхлэж, олсон орлогоосоо зохих хэмжээгээрээ Нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөн буюу ирээдүйдээ, тэтгэвэр тогтоолгоод сайхан амьдрах алхамаа хийсэн, үүргээ биелүүлсэн хүмүүс. Гэтэл тэдгээр нас барсан тэтгэврийн зээл авсан зээлдэгчийн өрийг үлдсэн ар гэрийнхэн нь төлөх үүрэг хүлээж байгаа нь буруу тогтолцоо байна. Тэтгэврийн зээл өндөр дүнтэй олгогдохгүй, тухайн иргэний авч байгаа тэтгэврийн хэмжээтэй уялдаж байгаа. Нас барсан тэтгэврийн зээл авагчийн төлсөн Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ тэдний авсан зээлийг төлөх хэмжээнд дүйцэхүйц бөгөөд шударга ёсонд нийцэх юм.

Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 5 заалттай. Өндөр настны тэтгэвэр авагч тэтгэврийн зээлд хамрагдаад түүнийгээ төлж барагдуулаагүй байхдаа нас барсан бол энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Энэхүү хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч иргэд банкнаас тэтгэврийн зээл авсан боловч төлж барагдуулаагүй байхдаа нас барсан бол түүний тэтгэврийн зээлийн чөлөөлж, төрөөс чөлөөлсөн тэтгэврийн зээлийг банкинд олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа тул нийгмийн даатгалын газар болон банкуудад нэмэлт ажилтан шаардагдахгүй, нэмэлт үйл ажиллагаа явуулахгүй, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.

Нас барсан зээлдэгч нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдаг учир төрийн зүгээс үргүй зардалд тооцогдохгүй.

Хуулийн төсөл батлагдсанаар тэтгэврийн зээл авагч нас барсан иргэний гэр бүл хайртай дотны хүнээ алдахаас гадна, нэмээд эдийн засгийн хувьд эрсдэлтэй үлддэг байдал байхгүй болно. Олон өрх айлд эдийн засаг, сэтгэл санааны эерэг байдал бий болно.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн болно.

НАС БАРСАН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ АВАГЧИЙН ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад үйлчилж байгаа нийгмийн хамгааллын бодлого шинэчлэн өөрчлөгдсөөр байгаа хэдий боловч зорилтод бүлгийн иргэдийн амьдралын наад захын хэрэгцээг хангахгүй, дутагдалтай байсаар байна. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн хэмжээ харилцан адилгүй, ялгаатай, Засгийн газраас амьжиргааны баталгаажих төвшинг тогтоосон мөнгөн дүнгээс дөнгөж дээгүүр байгаа байдал нь шударга, энэрэнгүй зарчимд суурилдаг манай улсын тэтгэврийн тогтолцоонд нийцэхгүй байгаагаас тэтгэвэр тогтоолгосон иргэдийн дийлэнх нь зээл авч, түүнийгээ төлж чадахгүй насан эцэслэж байна.

Сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ ханш эрс нэмэгдэж тэтгэвэр авагчдын худалдан авах чадварт, ялангуяа ахмад настануудын амьжиргаанд хүндээр байгаагаа ихэнх өндөр настангууд тэтгэврийн зээл авч амьжиргаагаа залгуулж байна.

2020 оны байдлаар Нийгмийн даатгалын сангаас нийт 441,201 мянган хүн өндөр насны тэтгэвэр авч байгаагаас 277,527 орчим нь 500,000 /таван зуун мянга/ төгрөгөөс доош тэтгэвэр авч байна. Үүнийг өрхийн дундаж зарлагын хэмжээтэй харьцуулан авч үзвэл нийт ахмадуудын 60 орчим хувь нь 500,000 /таван зуун мянга/ төгрөг хүрэхгүй тэтгэвэр авч, нэг өрхийн хоёр өндөр настан нийлээд дээр дурдсан өрхийн дундаж зарлагын 50 хувьд ч хүрэхээргүй хэмжээний тэтгэврийн орлогоор амьдарч байгаа бөгөөд энэ нь улс орон, үр хүүхэд, хойч ирээдүйнхээ төлөө насаараа зүтгэн хөдөлмөрлөсөн, тэтгэврээс өөр орлогогүй ахмадуудыг амьдралынхаа наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа тул тэтгэврийн зээл авч амьдарч байна.

Үндэсний статистикийн хорооноос Дэлхийн банктэй хамтран хоёр жил тутамд танилцуулдаг ядуурлын түвшингийн 2018 оны үзүүлэлтээр Монгол Улсын нийт хүн амын 28.4 хувь буюу 904,900 хүн ядуу амьдарч байгааг тогтоожээ.

Эдгээр ядуу иргэдийн тоонд өндөр насны тэтгэврээр амьдардаг ахмадуудын олонх нь хамаарах болсныг амьдралын бодит нөхцөл, авч буй тэтгэврийн хувь хэмжээ, тэдний авч буй тэтгэврийн зээлийн дүн нотлон харуулж байна.

Төрийн зүгээс нийгмийн даатгалын хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх, хүний амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн үүрэг юм. Тэтгэвэр авагч иргэн бол төрөөс зүгээр сууж байгаад халамж нэхэж, төсөвт хүндрэл учруулж байгаа иргэн биш, тэд ажиллаж хөдөлмөрлөж тодорхой хугацаанд ирээдүйд эдийн засгийн баталгаатай амьдрах үүднээс Нийгмийн даатгалын шимтгэлээ тухайн цаг үеийнхээ мөнгөний ханшаар төлсөн иргэн. Тэгэхээр өөрийн бий болгосон хуримтлалаа ирээдүйд авахдаа амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг нь хангаж чадахгүй, тэднийг ядууралд түлхэж тэтгэврийн зээл авахад хүргэж байна гэж дүгнэж байна.

Монгол Улсын иргэдийн дундаж наслалт эрэгтэй 66, эмэгтэй 75 байхад иргэдийн тэтгэврт гарах насыг нэмэгдүүлсэн нь олон жил хөдөлмөрлөж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэд тэтгэврийн насанд хүрээд тэтгэвэр авч чадахгүй эсхүл цөөхөн жил тэтгэвэр авахдаа зээлээс зээлийн хооронд амьдрасаар насан эцэслэж байгаа нь энэхүү хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлагатайг илэрхийлж байна.

Өндөр насны тэтгэврийн зээл аваад төлж чадаагүй нас барсан иргэд бол ажил хөдөлмөр эрхлэж, олсон орлогоосоо зохих хэмжээгээрээ Нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөн буюу ирээдүйдээ, тэтгэвэр тогтоолгоод сайхан амьдрах алхамаа хийсэн, үүргээ биелүүлсэн хүмүүс. Гэтэл тэдгээр нас барсан тэтгэврийн зээл авсан зээлдэгчийн өрийг үлдсэн ар гэрийнхэн нь төлөх үүрэг хүлээж байгаа нь буруу тогтолцоо байна. Тэтгэврийн зээл өндөр дүнтэй олгогдохгүй, тухайн иргэний авч байгаа тэтгэврийн хэмжээтэй уялдаж байгаа. Нас барсан тэтгэврийн зээл авагчийн төлсөн Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ тэдний авсан зээлийг төлөх хэмжээнд дүйцэхүйц бөгөөд шударга ёсонд нийцэх юм.

Хуулийн төсөл 5 заалттай. Өндөр настны тэтгэвэр авагч тэтгэврийн зээлд хамрагдаад түүнийгээ төлж барагдуулаагүй байхдаа нас барсан бол энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

Энэхүү хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч иргэд банкнаас тэтгэврийн зээл авсан боловч төлж барагдуулаагүй байхдаа нас барсан бол түүний тэтгэврийн зээлийн чөлөөлж, төрөөс чөлөөлсөн тэтгэврийн зээлийг банкинд олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа тул нийгмийн даатгалын газар болон банкуудад нэмэлт ажилтан шаардагдахгүй, нэмэлт үйл ажиллагаа явуулахгүй, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.

Нас барсан зээлдэгч нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдаг учир төрийн зүгээс үргүй зардалд тооцогдохгүй.

Хуулийн төсөл батлагдсанаар тэтгэврийн зээл авагч нас барсан иргэний гэр бүл хайртай дотны хүнээ алдахаас гадна, нэмээд эдийн засгийн хувьд эрсдэлтэй үлддэг байдал байхгүй болно. Олон өрх айлд эдийн засаг, сэтгэл санааны эерэг байдал бий болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НАС БАРСАН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ АВАГЧИЙН
ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч иргэн арилжааны банкнаас авсан тэтгэврийн зээлээ төлж барагдуулаагүй байхдаа нас барсан тохиолдолд төрөөс түүний тэтгэврийн зээлийг чөлөөлж, арилжааны банкинд төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Өндөр насны тэтгэврийн зээлийг чөлөөлөх тухай хууль тогтоомж

2.1. Нас барсан өндөр насны тэтгэврийн зээл авагчийн тэтгэврийн зээлийг чөлөөлөх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Банкны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль арилжааны банкнаас өндөр насны тэтгэврийн зээл аваад төлж амжилгүй нас барсан тэтгэврийн зээл авагчид хамаарна.

4 дүгээр зүйл.Тэтгэврийн зээлийг чөлөөлөх журам

4.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан нас барсан тэтгэврийн зээл авагчийн тэтгэврийн зээлийг Нийгмийн даатгалын сангаас арилжааны банкинд төлнө.

4.2. Засгийн газар энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан нас барсан тэтгэврийн зээл авагчийн тэтгэврийн зээлийг чөлөөлөх, арилжааны банкинд зээлийг шилжүүлэхэд баримтлах бүртгэл, тооцооны болон холбогдох бусад үйл ажиллагааны журмыг энэ хуульд нийцүүлэн боловсруулж батална.

5 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

5.1. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны санаачлан боловсруулсан Өндөр насны тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэн олгох тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

Төрөөс тэтгэврийн тогтолцооны асуудлыг зөв тодорхойлох, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлалыг бий болгох, шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд тэтгэврийн зөрүүг арилгах иргэдрүүгээ чиглэсэн олон нааштай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч бас төрөөс зайлшгүй зохицуулах шаардлагатай зарим асуудал байсаар байна.

Монгол Улсын иргэдийн дундаж наслалт эрэгтэй 66, эмэгтэй 75 байгаа нь тэтгэвэр тогтоох нас 60-65 байгаа манай улсын хувьд Нийгмийн даатгалын шимтгэл олон жил төлсөн ч өндөр насны тэтгэвэр авах үр шимээ хүртэж чадахгүй нас барж байгаа олон өндөр настан байгааг тодорхойлж байна. Олон жил хөдөлмөрлөж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэд тэтгэврийн насанд хүрээд тэтгэвэр авч чадахгүй эсхүл цөөхөн жил тэтгэвэр авахдаа зээлээс зээлийн хооронд амьдрасаар насан эцэслэж байгаа нь энэхүү хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлагатайг илэрхийлж байна.

Өндөр насны тэтгэврийн зээл аваад төлж чадаагүй нас барсан иргэд бол ажил хөдөлмөр эрхлэж, олсон орлогоосоо зохих хэмжээгээрээ Нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөн буюу ирээдүйдээ, тэтгэвэр тогтоолгоод сайхан амьдрах алхамаа хийсэн, үүргээ биелүүлсэн хүмүүс. Гэтэл тэдгээр нас барсан тэтгэврийн зээл авсан зээлдэгчийн өрийг үлдсэн ар гэрийнхэн нь төлөх үүрэг хүлээж байгаа нь буруу тогтолцоо байна. Тэтгэврийн зээл өндөр дүнтэй олгогдохгүй, тухайн иргэний авч байгаа тэтгэврийн хэмжээтэй уялдаж байгаа. Нас барсан тэтгэврийн зээл авагчийн төлсөн Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ тэдний авсан зээлийг төлөх хэмжээнд дүйцэхүйц бөгөөд шударга ёсонд нийцэх юм.

Манай улс Олон улсын валютын сангийн шаардлагаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг нэмэгдүүлж 60-65 болгосон явдал Монгол улсын иргэдийн дундаж наслалттай тохирохгүй байна.

Өндөр насны тэтгэврийн хэмжээ өнөөдрийн амьжиргааны наад захын хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байгаагийн улмаас өндөр настнууд тэтгэвэр барьцаалж зээл авах, өндөр хүү төлөх, зээл авснаар олон сар жилээр тэтгэвргүй байх зэрэг эрсдэлүүдийг даван туулж байгаа бөгөөд хамгийн харамсалтай нь тэтгэврийн зээлээ барагдуулж чадахгүй хорвоогийн мөнх бусыг үзэх явдал цөөнгүй байна.

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь Монгол Улсын иргэний Үндсэн хуульд заасан эрхийг бүрэн эдлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, Нийгмийн хамгааллын тогтолцоог шударга болгох зэрэгт оршино

ХОЁР.АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан нь төр иргэддээ шударга, энэрэнгүй бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэйг баталж байна.

1990 оны Тэтгэврийн хуульд төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн эхчүүд 20-иос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүй тэтгэвэр тогтоох, эмэгтэй 55 нас хүрсэн, эрэгтэй 60 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох зэрэг заалтууд хэрэгжих байсан нь олон иргэн маш бага хэмжээтэйгээр тэтгэвэр тогтоолгох үндсэн шалтгаан байсан. Түүнчлэн Олон улсын валютын сангийн шаардлагаар тэтгэврийн насыг нэмэгдүүлж 60-65 болгож хуулийн өөрчлөлт оруулсан нь Монгол улсын иргэдийн дундаж наслалт гэж статистикын газраас гаргасан эрэгтэй 66, эмэгтэй 75 настай тохирохгүй, насаараа хөдөлмөр эрхлэж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэд тэтгэврээ ч авч чадахгүй нас барах явдал маш их байна.

Хүний амьдралын наад захын хэрэглээг хангаж хүрэхгүй маш бага хэмжээний тэтгэвэр тогтоолгоно, гэтэл тэтгэвэрт гарах насыг нь өндрөөр тогтооно. Төр иргэнээ нийгмийн даатгалын шимтгэлээр торгож, мөлжиж байгаа дүр зураг харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ ханш нэмэгдэж тэтгэвэр авагчдын худалдан авах чадварт, ялангуяа ахмад настнуудын амьжиргаанд хүндээр тусах болсон.

Үндэсний статистикийн хорооноос Дэлхийн банктэй хамтран хоёр жил тутамд танилцуулдаг ядуурлын түвшингийн 2018 оны үзүүлэлтээр Монгол Улсын нийт хүн амын 28.4 хувь буюу 904,900 хүн ядуу амьдарч байгааг тогтоожээ.

Эдгээр ядуу иргэдийн тоонд өндөр насны тэтгэврээр амьдардаг ахмадуудын олонх нь хамаарах болсныг амьдралын бодит нөхцөл, авч буй тэтгэврийн нь хувь хэмжээ бүрэн нотлохоор байгаа бөгөөд нөгөө талаас гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч буй энэхүү эмгэнэлтэй үзүүлэлт нотлон харуулж байна. Авсан тэтгэвэр нь амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаагаас ахмадууд тэтгэврийн зээл авч амьжиргаагаа залгуулж байгаа нь шударга бус байна. Иймд энэхүү хууль нь цаг үеэ олсон маш чухал шаардлагатай хуулийн төсөл болсон байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газраас шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлж, тэтгэврийн доод хэмжээг маш бага хувь хэмжээгээр нэмэгдүүлж байгаа явдал нь иргэд үр өгөөжгүй, амьдралын чанарт ач холбогдолгүй, төсвөөс гарч байгаа хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсаар ирсэн. 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 21,3

мянган иргэн нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа бөгөөд эдгээрийн 15,4 мянга буюу 72,3 хувь нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүд, 4,0 мянга буюу 18,9 хувь нь 27 жил ажиллан нас харгалзахгүй тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд, 1,8 мянга буюу 8,7 хувь нь 32 жил ажиллан 55 насанд хүрсэн эрэгтэйчүүд эзэлж байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд өнөөдрийн байдлаар өндөр настны бүрэн тэтгэврийн доод хэмжээ ердөө 310 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн дээд хэмжээ 270 мянган төгрөг байгаа нь хүний амьдралын нэг сарын хэрэгцээг хангах боломжгүй юм.

Үүнээс дүгнэхэд нийгмийн даатгалын хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх, хүний амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн үүрэг юм. Тэтгэвэр авагч иргэн бол төрөөс зүгээр сууж байгаад халамж нэхэж, төсөвт хүндрэл учруулж байгаа иргэн биш, тэд ажиллаж хөдөлмөрлөж тодорхой хугацаанд ирээдүйд эдийн засгийн баталгаатай амьдрах үүднээс Нийгмийн даатгалын шимтгэлээ тухайн цаг үеийнхээ мөнгөний ханшаар төлсөн иргэн. Тэгэхээр өөрийн бий болгосон хуримтлалаа ирээдүйд авахдаа амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг нь хангаж чадахгүй, тэднийг ядууралд түлхэж байгаа нь шударга бус бөгөөд нэгэнт тэтгэврийн зээл аваад төлж чадалгүй нас барсан зээлдэгчийн зээлийг төрийн зүгээс нэг удаа чөлөөлж өгөх нь шударга бөгөөд, тэдний ар гэрийн зүгээс ч энэхүү шударга тогтолцоонд талархалтай байх болно.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЗЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, зерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1 Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Өндөр насны тэтгэврийн зээлд хамрагдсан ч зээлээ төлж чадалгүй нас барсан зээлдэгч хуульд хамрагдана.	Нийгмийн даатгалын шимтэл төлж шаардлага хангаж өндөр насны тэтгэвэр тогтоолгож тэтгэврийн зээл аваад төлж чадаагүй нас барсан зээлдэгчийн зээлийг чөлөөлнө.
2 Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Нас барсан өндөр насны тэтгэврийн зээлдэгчийн зээлийг чөлөөлөх	Улсын төсвөөс санхүүжүүлнэ. Гэвч нас барсан зээлдэгч нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдаг учир төрийн зүгээс үргүй зардал биш

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцнэ
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шударга, тэгш, зэрэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	энэ асуудалтай холбогдолгүй
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх			
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Зардал гарахгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

мэдээлэл, ёс суртахуун	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-г нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

-----oOo-----

**НАС БАРСАН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ АВАГЧИЙН
ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙНТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны санаачлан боловсруулсан нас барсан өндөр насны тэтгэврийн зээл авагчийн тэтгэврийн зээлийг чөлөөлөх тухай хуулийн төслийн /цаашид "Хуулийн төсөл" гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан анхдагч хуулийн төсөл төрлөөр боловсруулагдсан хувилбар байв. Хуулийн төсөл нь 5 зүйлээс бүрдэж байна.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал"¹-д /цаашид "аргачлал" гэх/ заасны дагуу хийлээ.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Харилцан уялдаа зэрэг болно.

"**Зорилгод хүрэх байдал**" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгов.

"**Ойлгомжтой байдал**" гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд болон хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой боловсруулагдсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс үнэлэхийг зорьж сонголоо.

"**Харилцан уялдаа**" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хуульд нэмэлт оруулах төсөл тул хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд болон хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо нийцсэн эсэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр сонгосон болно.

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Хуулийн төслийг боловсруулахдаа өндөр насны тэтгэвэр авагч тэтгэврийн зээл аваад түүнийгээ төлж амжилгүй нас барсан бол энэ хуулийн зохицуулалтад хамаарна.

Иймд энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасанд үнэлгээ хийхээр сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

/Хуулийн төсөл 5 зүйлтэй./

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

/Хуулийн төсөл 5 зүйлтэй./

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <u>ойлгомжтой байдлыг</u> шалгах.
3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төслийн үзэл баримтлалаас харахад өндөр насны тэтгэвэр авагч арилжааны банкнаас тэтгэврийн зээл аваад түүнийгээ төлж амжилгүй нас барсан бол энэ хуулийн зохицуулалтад хамаарахаар байна.

Үнэлгээ хийхээр сонгож авсан зохицуулалтын хувьд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцэж, хуулийн төслийн зорилтыг хангах боломжтой байна.

Хэдийгээр төр засгаас тодорхой арга хэмжээ авч ирсэн боловч өндөр насны тэтгэврийн хэмжээ Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих төвшингөөс дөнгөж л дээгүүр байгаа нь иргэдийн амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангахгүй, өндөр настнууд арга буюу тэтгэврийн зээл авч өдөр хоногийн өнгөрөөж байгаа нь бодитой байна.

Төрийн зүгээс нийгмийн даатгалын хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх, хүний амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн үүрэг юм. Тэтгэвэр авагч иргэн бол төрөөс зүгээр сууж байгаад халамж нэхэж, төсөвт хүндрэл учруулж байгаа иргэн биш, тэд ажиллаж хөдөлмөрлөж тодорхой хугацаанд ирээдүйд эдийн засгийн баталгаатай амьдрах үүднээс Нийгмийн даатгалын шимтгэлээ тухайн цаг үеийнхээ мөнгөний ханшаар төлсөн иргэн. Тэгэхээр өөрийн бий болгосон хуримтлалаа ирээдүйд авахдаа амьдралын наад захын хэрэгцээг нь хангахуйц тэтгэвэр авдаг бол тэтгэврийн зээл авагчдын тоо тийм их байхгүй байх боломжтой.

Монгол Улсын иргэдийн дундаж наслалт эрэгтэй 66, эмэгтэй 75 байхад иргэдийн тэтгэврт гарах насыг нэмэгдүүлсэн нь олон жил хөдөлмөрлөж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэд тэтгэврийн насанд хүрээд тэтгэвэр авч чадахгүй эсхүл цөөхөн жил тэтгэвэр авахдаа зээлээс зээлийн хооронд амьдрасаар насан эцэслэж байгааг тэдний төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг хуримтлуулагч төр анхаарах ёстой. Төрөөс үргүй зардал гарахгүй, Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч иргэдийн хуримтлалаас тэдэнд зориулах гэж байгаа учир энэхүү хуулийн төсөл зорилгодоо хүрэх бүрэн боломжтой.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараахь асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагагүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагагүй.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорьлоо.

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа
2	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
3	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
6	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
7	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
8	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
9	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
10	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.

11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
12	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хориглосон хэм хэмжээ тусгаагүй тул шаардлагагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. Нас барсан өндөр насны тэтгэврийн зээл авагчийн тэтгэврийн зээлийг чөлөөлөх тухай хуулийн төслийн;

2. Үндэсний статистикийн газраас гаргаж буй судалгаа;

3. Монголбанкаас гаргаж буй судалгаа;

4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын судалгаа;

5.2.Дүгнэлт

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийсэн.

Хуулийн төслийн 1,2,3,4 дүгээр зүйлүүдийн хувьд хуулийн төслийн үзэл баримтлал болон энэхүү хуулийг төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлагатай нийцэж байгаа нь зорилгод хүрэх, ойлгомтой байх, бусад хууль тогтоомжтой нийцсэн, давхардалгүй, зөрчилгүй томъёологдсон байна.

Хуулийн төсөлд арилжааны банкуудтай хэрхэн харилцах, тэдэнд зээлдэгчийн төлбөрийг хэрхэн барагдуулах талаар нарийвчлан тусгах нь журмаас илүүтэй байх гэж харагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэж заасан. Өөрөө хэлбэл төр өндөр настан, тэтгэвэр авагч иргэдийнхээ амьдралын наад захын хэрэгцээ, шаардлагыг хангуйц тэтгэвэр тогтоож олгох үүрэгтэй гэсэн үг. Төр хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээс тухайн цаг хугацааны мөнгөний ханш, инфляцийн төвшин, эдийн засгийн байдалд уялдуулж нийгмийн даатгалын шимтгэлийг авдаг. Гэтэл шимтгэл төлсөн иргэд нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох үедээ төрийн

бодлого буруу, төр ажлаа зүй зохистой хийхгүй байгаагаас шударга бус тогтоож байгаа амьдралын наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй хэмжээний мөнгөөр ядуу амьдралруу гулсан орж, өдрийн хоолоо таслахгүйн тулд тэтгэврийн зээл авч байгаа нь бодитой байна. Өөрөөс шалтгаалахгүй нөхцөл байдлаас болж ядуу амьдарч байгаа нь тэдний буруу биш. Иймд төр зүй зохистой бодлого хэрэгжүүлж, тэтгэвэр авагчдын амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангах хэмжээний тэтгэвэр тогтоож олгох нь зүй ёсны шаардлагад нийцэх бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлж хуримтлал үүсгэсэн иргэдийнхээ тэтгэврийн зээл аваад төлж амжилгүй нас барсан тохиолдлыг нэг удаад чөлөөлөх нь шударга гэж дүгнэж байна. Иймд хуулийн төсөл дэмжигдэх болон хэрэгжих бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

-----oOo-----

НАС БАРСАН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛДЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА

Нас барсан өндөр насны тэтгэврийн зээлдэгчийн тэтгэврийн зээлийг чөлөөлөх тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу хийсэн болно.

Өнөөдөр өндөр насны дундаж тэтгэвэр 500 мянга хүрэхгүй, амьжиргааны наад захын шаардлагыг хангахгүй байгаа учир ахмадууд тэтгэврийн зээлд хамрагдаж, эдийн засгийн асуудлаа шийдвэрлэж байна.

Үзүүлэлт <i>Хэмжих нэгж: мян.хүн</i>	2019	2020-12	2020	2021-10
Өндөр настны тэтгэвэр авагчид	307.5	338,982	332.9	350,778

Эх сурвалж: 1212.mn

2021 оны 10 дугаар сарын байдлаар Нийгмийн даатгалын санг (НДС)-аас тэтгэвэр авдаг 350 778 мянган ахмадууд байгаа бөгөөд тэтгэврийн зээл авсан зээлдэгчид дээрх хуульд хамрагдана.

Өнөөдөр 230 гаруй мянган ахмад тэтгэврийн зээлийг арилжааны банкуудаас авсан судалгаа байна. Ахмадууд ихэнхдээ 2 дугаар сард тэтгэврийн урьдчилгаа авч цагаан сар тэмдгэлэхээс гадна намар ач, зээ нарынхаа сургалтын төлбөрт нэмэр болох зэргээр багахаан зээлийг бага хугацаатайгаар авдаг нь нийтлэг байдаг талаар арилжааны банкууд мэдээлж байна. Тэтгэвэр авдаг ахмадууд өөр мөнгөн орлого байхгүй тул аль болох зээл авхаасаа болгомжилог.

Хуулийн төсөл хэрэгжихтэй холбогдон гарах зардлыг төр хариуцана. Гэхдээ энэ нь зөвхөн төр бүрэн хариуцана гэсэн үг биш. Учир нь иргэн хөдөлмөрлөх хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэл төлж тэтгэврийн нэрийн дансандаа хуримтлал үүсгэсэн байдаг бөгөөд түүнээс төлөгдөж байна гэж үзэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл төр шууд утгаараа төлж байгаа гэсэн үг биш. Тухайн тэтгэврийн зээлдэгч байсан иргэнээр төлүүлж байгаа гэсэн үг юм.

Монгол улсын иргэдийн дундаж наслалтыг Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанаас харвал эрэгтэй 66, эмэгтэй 76, нийт дундаж наслалтыг 70 гэж гаргасан байна.

Статистик үзүүлэлт	Аймаг	Аймгийн код	2018	2019	2020
Нийт	Улсын дүн	0	70.19	70.41	70.71
Эрэгтэй	Улсын дүн	0	66.11	66.38	66.71
Эмэгтэй	Улсын дүн	0	75.78	75.96	76.22

<http://1212.mn/tables.aspx>

Монгол улсын төр иргэдээ ид хөдөлмөр хийж олсон орлогоос нь ирээдүйд чинь сайхан амьдруулна хэмээн нийгмийн даатгалын шимтгэл суутгаж үүсгэсэн хуримтлалаас нь амьдралын наад захын хэрэгцээг нь хангахуйц тэтгэвэр олгож чадахгүй, иргэдээ эдийн засаг, нийгмийн хувьд сайхан амьдруулах нөхцөлийг бүрдүүлэх үүргээ биелүүлж чадахгүйн дээр тэтгэвэр тогтоолгоод олон жил тэтгэвэр авч чадалгүй нас барсан иргэддээ нэг удаа уян хатан бодлого хэрэгжүүлэх нь зүй ёсны үүрэг нь юм.

Тэтгэвэр авагч 120 гаруй мянган иргэн 3 хүртэлх сая төгрөгийн, 150 орчим мянган ахмад 4 сая хүртэлх нийтдээ тэтгэврийн зээлтэй, тэтгэвэр авагч ахмадуудын 10 орчим хувь нь 6 саяас дээш төгрөгийн тэтгэврийн зээлтэй гэдэг судалгаа байна.

-----oOo-----

Саналын товъёог

Д/Д	Санал	Тайлбар
1	Дэмжиж байна. Мөн НД төлж ажлаа хийж байгаад нас барсан иргэний цалингийн зээлийг бас оруулах хэрэгтэй байх гэж бодож байна.	Дэмжигдээгүй
2	Хөгшин настай хүмүүсрүүгээ чиглэсэн нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ тэдний авсан зээлийг төлөх хэмжээнд дүйцэхүйц бөгөөд шударга ёсонд нийцэх хууль хэрэгтэй байгаа	Дэмжигдсэн
3	Жирийн ард иргэдээ бодсон ядуу иргэн ихтэй манай улсад чухал хэрэгтэй маш сайхан хууль санаачилжээ	Дэмжигдсэн
4	Тэтгэврээ төлж чадалгүй нас барсан настнуудын ард үлдэж байгаа гэр бүлийг дэмжсэн сайхан хууль санагдлаа дэмжиж байна	Дэмжигдсэн
5	Нас барсан хүмүүсийн ар гэр тайван байж болохоор болох нь	
6	Таалагдлаа өндөр настнуудын амьдрал хүнд хэцүү байгаа. Ядуусын тоонд ахмад настнууд ихээр бий	Дэмжигдсэн
7	Дэмжиж байна Монголын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ ханш эрс нэмэгдэж тэтгэвэр авагчдын худалдан авах чадварт, ялангуяа ахмад настнуудын амьжиргаанд хүндээр байгаагаа ихэнх өндөр настангууд тэтгэврийн зээл авч амьжиргаагаа залгуулж байна	Дэмжигдсэн
8	Төрийн зүгээс нийгмийн даатгалын хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх, хүний амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн үүрэг юм. Тэтгэвэр авагч иргэн бол төрөөс зүгээр сууж байгаад халамж нэхэж, төсөвт хүндрэл учруулж байгаа иргэн биш, тэд ажиллаж хөдөлмөрлөж тодорхой хугацаанд ирээдүйд эдийн засгийн баталгаатай амьдрах үүднээс Нийгмийн даатгалын шимтгэлээ тухайн цаг үеийнхээ мөнгөний ханшаар төлсөн иргэн. Тэгэхээр өөрийн бий болгосон хуримтлалаа ирээдүйд авахдаа амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг нь хангаж чадахгүй, тэднийг ядууралд түлхэж тэтгэврийн зээл авахад хүргэж байна эерэг нөлөө бүхий хууль гэж бодож байна.	Дэмжигдсэн
9	Дундаж наслалт бага манай улсын хувьд хэрэгтэй гэж бодож байна.	Дэмжигдсэн
10	Нас барсан тэтгэврийн зээл авсан зээлдэгчийн өрийг үлдсэн ар гэрийнхэн нь төлөх үүрэг хүлээж байгаа нь буруу тогтолцоотой манайд хэрэгтэй хууль.	
11	Нас барсан зээлдэгч нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдаг учир төрийн зүгээс үргүй зардалд тооцогдохгүй	Дэмжигдсэн

